



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/311

Мандалговь

Хүүхдийн спортын VI наадамд оролцогчдод
хөрөнгө гаргах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1.2, Бага дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл 18.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 354 дугаар тогтоол, 2018 оны 183 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/777 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монголын хүүхдийн спортын VI наадамд оролцох баг тамирчдын бэлтгэлийг бүрэн хангаж, оролцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Монголын хүүхдийн спортын VI наадамд оролцох баг тамирчдын зардал 5,000,000 (таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

48819 904